



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 09

Есөнбулаг сум

Тогтоолын хэрэгжилтийг хангах тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12, 22 дугаар зүйлийн 22.1.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 70, 94, 2012 оны 17, 18, 2013 оны 15, 2015 оны 14 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулан хүчин төгөлдөр мөрдөж байгаа “Аймгийн шагналын журам”-ын хэрэгжилтийг 2-р сард багтаан тайлагнаж, аймгийн шагналын журмыг шинэчлэн боловсруулж, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д үүрэг болгосугай.

2. “Аймгийн аварга малчин”, “Аймгийн аварга саальчин”, “Аймгийн аварга фермер”, “Аймгийн аварга тариаланч хамт олон”, “Аймгийн аварга тариаланч” “Аймгийн аварга хадланч”-ийг шалгаруулах ажлын явц, дүнг ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж, зөвшилцсөний үндсэн дээр шийдвэр гаргаж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ